



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 1/НЗ1.

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулий 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх хэсэг, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Жаргалант сумын Жаргалан баг Орчлон 1 дүгээр гудамжны 107 тоотод байрлах, автомашины гаражны зориулалттай Мөнгөнхүүгийн Ганболд /ПД58110172/-ийн эзэмшлийн 35 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Дүүрийчимэдийн Мөнхцоож /ПЮ81022305/-д автомашины гаражны зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Буянт баг Эко 3 дугаар гудамжны 1 тоотод байрлах амины орон сууцны зориулалттай Баастын Батболд /ПЮ68123110/-ийн эзэмшлийн 591 метр квадрат газар, Жаргалант сумын Буянт баг Эко 3 дугаар гудамжны 2 тоотод байрлах амины орон сууцны зориулалттай Баасангийн Чимэдцэрэн /ПН77031301/-ийн эзэмшлийн 551 метр квадрат газруудыг нэгтгэн 1142 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Мөнхтүвшингийн Төрхүү /ПЖ96083118/-д гэр, орон сууцны зориулалтаар хаягийг Хөгжлийн 1 дүгээр гудамжны 102 тоот болгон 9 жилийн хугацаагаар,

3. Жаргалант сумын Буянт баг Жаргалант хайрхан 1 дүгээр гудамжны 134 ө тоотод байрлах, гэр, орон сууцны зориулалттай Батхүүгийн Хатанзориг /ПЮ74110316/-ийн эзэмшлийн 3500 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Алтанцэцэгийн Болор-Эрдэнэ /ПЮ95070700/-д гэр, орон сууцны зориулалтаар 13 жилийн хугацаагаар,

4. Жаргалант сумын Алагтолгой баг Баянбулаг 3 дугаар гудамжны 309 а тоотод байрлах, худалдаа, үйлчилгээний зориулалттай Жанцангийн Рагчаадорж /ПЮ50721019/-ийн эзэмшлийн 1000 метр квадрат газраас 47 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Дамиранжавын Батсайхан /БД79111712/-д худалдаа, үйлчилгээний зориулалтаар, хаягийг Баянбулаг 3 дугаар гудамжны 309 б тоот болгон 15 жилийн хугацаагаар, үлдсэн 953 метр квадрат газрыг Жанцангийн Рагчаадорж /ПЮ50721019/-д худалдаа, үйлчилгээний зориулалтаар хаягийг Баянбулаг 3 дугаар гудамжны 309 а тоот болгон тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

5. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлэхийг дээрх иргэдэд үүрэг болгосугай.

6. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэдтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ